

**Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл**



## **ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН**

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ**

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГУУЛЬ**

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД D091801**

**БАКАЛАВРЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**УЛААНБААТАР ХОТ 2017 ОН**

**“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД” бакалаврын сургалтын хөтөлбөрийн  
шинжээчийн тайлан**

**Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

- Нийгэм эдийн засгийн хөгжил; Нийгмийн эрүүл мэндийн салбарын дэлхийн чиг хандлага; эрүүл мэндийн байгууллага болон аж ахуйн нэгжийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны нормыг баталгаажуулсан Монгол улсын хууль, тушаал, шийдвэр, стандартуудын заалтууд; нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн ажлын байрны хэрэгцээ эрүүл мэнд, мэргэжлийн хяналтын салбарын байгууллагуудад төдийгүй төрийн болон хувийн хэвшлийн бүх салбарын байгууллага, аж ахуйн нэгжүүдэд өсөн нэмэгдэж буйг нотлох судалгааны үр дүнгүүд, статистикийн тоо баримтууд; 2013, 2015, 2016, 2017 онд төгсөгч, ажил олгогчдоос авсан саналууд, гадаадын их дээд сургуулиудын НЭМ хичээлийн хөтөлбөртэй харьцуулан ялгаатай, давуу, сул талууд болон сайжруулах боломжуудыг тодорхойлсон дүн шинжилгээг үндэслэн Нийгмийн эрүүл мэнд бакалаврын сургалтын хэрэгцээг тогтоосон.
- "Нийгмийн Эрүүл Мэнд" бакалаврын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээс хойш 2008, 2015 онуудад 2 удаа шинэчилсэн. Хөтөлбөрийн сүүлийн хувилбар нь 2016 онд АШУҮИС-ийн Захирлын Зөвлөл, Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцүүлэгдэн, АШУҮИС-ийн захирлаар баталгаажуулсан
- Сургалтын төлөвлөгөөг шинэчлэх зорилгоор эрүүл мэндийн, түүний дотор нийгмийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, мэргэжил, мэргэжилтний ажлын байрны шаардлагатай хамааралтай хууль эрх зүй, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд болон гадаадын их сургуулиудын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, өөрийн сургуулийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг ханган ажиллаж байгаа.

**Зөвлөмж:**

1. Харьцуулалт хийх сургуулиудын олон улсад танигдсан, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн түвшингийн үнэлгээг тайландаа тусгаж өгөх

## 1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

- ЭМ-ийн сайдын 2012 оны 168 тоот тушаал, БШУ-ны сайдын А/174 тоот тушаал, **2021 он хүртэлх “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал”**, АШУҮИС-ийн эрхэм зорилго, сургуулийг 2015-2024 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг хангах зорилгоор *судалгаанд суурилан ур чадвар, арга барил олгох сургалтын арга зүйг голлон ашиглаж* “Даяаршил, тасралтгүй төгөлдөршил, цахимжилтын эринд дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах мэдлэг боловсролтой, урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээ, нөхөн сэргээх өндөр технологийг эзэмшсэн, хүнлэг энэрэнгүй ёс суртахуун, ёс зүйтэй, төлөвшсөн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн” гаргахад хөтөлбөрийн үндсэн агуулгыг чиглүүлсэн.
- “Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: нийгмийн эрүүл мэнд. MNS 5323-125:2012” стандартад, ЭМ-ийн сайдын 2012 оны 102 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн” мэргэжлээр баклавын зэрэгтэй төгсөгчид тавигдах шаардлага”-ыг хангасан бөгөөд уг мэргэжилтэн нь НЭМ-ийн шинжээч, судлаач, бодлого боловсруулагч, манлайлагч мэргэжилтэн бэлтгэх зорилгоор 8 хүрээний нийт 95 ур чадварыг багтаасан “НЭМ-ийн мэргэжилтний эзэмшвэл зохих цогц чадамж”-ийг боловсруулж, зааж буй хичээлийн хөтөлбөрийн агуулгад тусгах, шаардлагатай хичээлүүдийг нэмж оруулах зэрэг өөрчлөлтүүдийг хийсэн.
- Оюутанд сонгон суралцах боломж бүрдүүлэх эхлэл тавигдсан бөгөөд сонгон суралцах хичээл нийт багц цагийн 7.3% (12 багц цаг)-г эзэлж байна. Хичээлийн төлөвлөгөөнд тусгасан нийт цагийн 25 хүртэл хувийг зайны сургалт (Е-контент)-д шилжүүлэх зорилт тавьсан. Сургалтын төлөвлөгөө онолыг практиктай холбон, онолын мэдлэгийг мэргэжлийн чадвар, дадал болгоход чиглүүлсэн, түүний хүрээнд талбарын дадлага буюу дадлагажих хичээл 5.5% (9 багц цаг)-ийг эзэлдэг.
- Хөтөлбөрийн үзэл баримтлал нь Их сургуулийн эрхэм зорилготой уялдсан, суралцагчдад НЭМ-ийн шинжээч, судлаач, бодлого боловсруулагч, манлайлагч байх ур чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн
- Мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төгсөгчийн зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагыг “НЭМ-ийн мэргэжилтний цогц чадамж” баримт бичигт тусгаж, хөтөлбөрийн агуулга, заах аргазүйд шинэчлэл хийсэн.
- Сургалтад сонгон суралцах, Е-контент ашиглан зайнаас сургах, оюутныг бие даалган сургах арга зүйг нэвтрүүлж эхэлсэн, өргөжүүлэх, боловсронгуй болгох зорилт тавин ажиллаж байгаа.

### 1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### Дүгнэлт:

- БСШУ-ны Сайдын 2014 оны 04 сарын 28-ний өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан "Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага"-ыг хангах зорилгоор НЭМ хөтөлбөрийн төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын орчин, заах арга зүй, оюутнуудын эзэмших мэдлэг болон ур чадварын үнэлгээ, багш болон элсэгчдэд тавигдах шаардлагыг багтаасан, асуудлуудыг зохицуулах 7 журмыг 2015-2016 онд шинэчлэн мөрдөж байгаа.
- "Нийгмийн Эрүүл Мэнд" бакалаврын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээс хойш 2008, 2015 онуудад 2 удаа шинэчилсэн. Хөтөлбөрийн сүүлийн хувилбар нь 2016 онд АШУҮИС-ийн Захирлаар батлагдсан.
- НЭМ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулга нь эрүүл мэндийн салбар, хувийн хэвшлийн салбар, аж ахуйн нэгж болон бусад салбарт нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эрүүл ахуйч, тархвар судлаачаар ажиллахад шаардагдах шинжээч, судлаач, бодлого боловсруулагч, үйл ажиллагааг хэрэгжүүлэгч, үнэлэгч байх ур чадварыг олгоход чиглэсэн.
- Сургалтын хөтөлбөр дэх хичээлүүдийг онцлогт нь тохируулан лекц, дадлага (лабораторийн, талбарын), семинар, бие даалт хэлбэрээр явуулдаг бөгөөд оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан чадамжид суурилсан, дагалдуулан, үлгэрлэн сургах, судалгаанд суурилсан зэрэг *сургалтыг арга зүйг* ашигладаг.
- НЭМ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эрүүл ахуйч, тархвар судлаачийн эзэмшвэл зохиох цогц чадамжийг суралцагчдад эзэмшүүлэхэд шаардлагатай агуулгуудыг багтаасан, үр дүнд чиглэсэн арга зүйтэй; олон аргуудаар тэдний мэдлэг ур чадварыг үнэлдэг байна.
- Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган өмнөх магадлан итгэмжлэлээс хойш 2 удаа шинэчилсэн.

**1-р бүлгийн шинжээчийн нэгдсэн үнэлгээ:** Бүрэн хангасан

## Шалгуур 2. СУРГАЛТЫН ОРЧИН, НӨХЦӨЛ

### 2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, сургалт явуулах орчинг сайжруулсан. Нэг оюутанд ногдох талбай  $2.85\text{м}^2$  болж мэргэшүүлэх чиглэлээр бага бүлгээр хичээллэх оюутны тоо 15-аас ихгүй болж, оюутан бүр компьютер дээр ажиллах боломж нөхцлөөр хангагдан нэг ангид 20-оос ихгүй оюутан, суудлын тоо 22 байгаа нь БСШУЯ-ны сайдын 74 тоот тушаалын хавсралтын заалтыг бүрэн хангасан байна. НЭМС сүүлийн 5 жилд сургалтын 3 лаборатори, судалгааны арга зүйн төвийн тоног төхөөрөмж, хангамжийг 60 хүртэл хувиар өргөтгөн шинээр 19 багаж тоног төхөөрөмж нийлүүлэн, 8 шинэ лабораторийн хэмжилт туршилтын арга хэрэглэж эхэлсэн.

Хичээлийн өрөөнүүд сургалтын байранд тавигдах эрүүл ахуйн үзүүлэлтүүд болох гэрэлтүүлэг, чийглэг, температурын норм хэмжээг бүрэн хангасан байна. Мөн ээлжийн ашиглалтын коэффициент (N) 1.5-аас ихгүй байгаа нь стандартыг хангаж, оюутан суралцах эрүүл аюулгүй тохилог орчинг бүрдүүлэн ажиллажээ. Багш нарын ажиллах орчныг сайжруулж, багш нарын өрөөний талбайг 80 орчим  $\text{м}^2$ -р нэмэгдүүлсэн. Нэг багшид ногдох талбай стандарт хэмжээг ( $4\text{ м}^2$ -аас багагүй байхаар заасан) бүрэн хангасан,,

АШУҮИС болон НЭМС нь сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа хэвийн явуулах, оюутан багш нарын суралцах, ажиллах орчны талбайг шинээр бүтээн байгуулалт хийх замаар бүрдүүлэх, сургалтанд шаардагдах материаллаг болон материаллаг бус орчинг бүрдүүлсэн байна.

## **2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

НЭМС дээр 30 гаруй компьютер бүхий нийт  $68\text{ м}^2$  талбайтай судалгааны арга зүйн төв болон компьютерийн лабораторийг өргөтгөн, тэдгээрийг интернетэд холбон компьютерийн өргөн хэрэглээний статистик программ хангамжууд SPSS, STATA, Arc View зэргийг суулган, сургалтанд ашиглаж байна. Сургалт судалгааны программ хангамж хичээлийн хэрэгсэл, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмжийг сайжруулахад зориулан сүүлийн таван жилд 1, 095,643,862 хөрөнгө оруулалтыг АШУҮИС, НЭМС болон бусад хамтран ажилласан гадны байгууллагаас зарцуулсан байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд оюутнуудад зориулж мэргэжлийн 40 гаруй нэр төрлийн 6,943,500 төгрөгийн сурах бичиг, гарын авлага зэргийг худалдан авч нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш нар 2011-2015 онд мэргэжлийн хичээл тус бүрээр 96 сурах бичиг, гарын авлага боловсруулан сургалтанд ашиглажээ.

НЭМ мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн сургалтын лабораторийг чадавхижуулах төлөвлөгөө гарган шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авч сургалт болон эрдэм шинжилгээний зорилгоор ашиглаж, сургалтанд ашиглах олон улсын хэмжээний статистик программыг Судалгааны арга зүйн төв болон Компьютерийн лабораторийн компьютерүүдэд суурилуулан, мэргэжлийн багшийн удирдлаганд

төгсөлтийн өмнөх болон дараах сургалтыг явуулж байна. Сургалтын материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал хэрэглэгдэхүүний хүртээмжийг 2 дахин нэмсэн.

#### **Зөвлөмж:**

Төрийн өмчит их дээд сургуулийн сургалтын лабораторийг чадавхижуулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд бодлогоор дэмжих асуудлыг Засгийн газар, холбогдох яамдад санал тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй.

### **2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

АШУҮИС нь 2015 онд номын сангийн нийт талбайг 848 м<sup>2</sup> талбайтай болгон нэмэгдүүлж, 336 суудлыг шинээр бий болгосон. Номын фондын 72% нь анагаахын ном, 17% нь монгол хэлээр, 55% нь орос хэлээр, 28 % нь англи хэлээр бичигдсэн бүтээлүүд байна. Сүүлийн 5 жилд НЭМ бакалаврын сургалтанд ашиглагдаж буй ном, гарын авлага, сурах бичгийн тоо 2 дахин нэмэгдсэн. АШУҮИС–д одоогоор цахим ном 4258, мультимедиа 9805, эрдмийн бүтээл 1095, цахим лекц 226, гадаадын сэтгүүл англи хэл дээр 23, орос хэл дээр 15, монгол 7 сэтгүүл, 3 төрлийн сонинг цахим хэлбэрээр хүргэж байна. Цахим номын сангийн ашиглалтанд 2 танхимд 25 компьютер, 22 ipad хэрэглэж байна. HINARI хандалтыг 2005 оноос 2014 он хүртэл номын санд үнэ төлбөргүй ашиглаж иржээ.

Цахим номын сангийн ашиглалтыг сайжруулахаар багш, оюутанд зориулсан цуврал сургалтыг 2014-2016 онуудад 31 удаа явуулж, 761 багш, оюутан эмч нар хамрагдсан. Номын санг автоматжуулах Юнескогийн CDS/ISIS программыг анхлан хэрэглэсэн. АШУҮИС болон НЭМС-ийн орчинд wireless internet-г суурилуулснаар багш оюутнууд өөрсдийн компьютерийг ашиглан мэдээлэл авах боломж бүрджээ.

**2-р бүлгийн шинжээчийн нэгдсэн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Шалгуур 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

#### **3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

АШУҮИС нь 2013 онд “АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, 2014-2024” төлөвлөгөөг боловсруулан баталж мөрдөн ажиллаж, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, чадварлаг хүний нөөцийн баг бүрдүүлэх талаар тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төгсөлтийн өмнөх сургалтын бакалаврын болон дипломын зэрэг олгох хөтөлбөрийн зөвлөлийг АШУҮИС-ийн захирлын 2015 оны 10-р сарын 09-ний өдрийн А/113 тоот тушаалаар байгуулсан. АШУҮИС-ийн суралцагчийг үнэлэх журам, АШУҮИС-ийн сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам, АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам зэргийг шинэчлэн баталсан. АШУҮИС-ийн СБЗГ-ын дэргэд багш нарын тасралтгүй хөгжих үйл ажиллагааг дэмжих, боловсролын судалгааны арга зүй эзэмшүүлэх, сурган заах арга зүйн орчин үеийн ойлголт, мэдлэгийг хэрэгжүүлэх зорилгоор “Багшийн хөгжлийн төв”-ийг байгуулсан.

Хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд зохион байгуулагдсан их сургуулийн болон бүрэлдэхүүн сургуулиудын Хөтөлбөрийн зөвлөлүүдийн үндсэн үүрэг, хариуцлага тодорхой болсон байна.

Сургалтын технологийг сайжруулах, багшийн чадавхийг нэмэгдүүлэх, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байгаа төдийгүй сургалтын технологийн дотоод хяналтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг эргэн мэдээлэх, гарсан шийдвэрийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой хугацаанд төлөвлөж ажиллаж байна.

#### **Зөвлөмж:**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарыг төгсөгчдийг хүлээн авч ажиллуулдаг байгууллагуудтай хамтран ажиллах, тэдэнтэй санал солилцох үр дүнг сургалтын хөтөлбөрт тусгах талаар санаачилгатай ажиллах

### **3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

АШУҮИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын алба болон Оюутны албанаас хөтөлбөр, түүнтэй холбоотой мэдээллүүд, элсэлтийн журам зэргийг АШУҮИС-ийн [www.mnums.edu.mn](http://www.mnums.edu.mn) вэб хуудас болон БСШУЯ-ны [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn) портал сайтаар дамжуулан, мөн сонин сэтгүүл болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд мэдээлдэг. Жил бүрийн хичээлийн шинэ жилийн эхэнд мэргэжлээ сонгох гэж буй оюутнуудад хөтөлбөр сурталчлах уулзалт зохион байгуулдаг. Сургалтын хөтөлбөрийн талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх үйл ажиллагаа тогтмол зохион байгуулагддаг

#### **Зөвлөмж:**

Сургалтын хөтөлбөрийг идэвхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийн хувийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах хэрэгтэй.

### **3.3 Төгсөлтийн дараах бодлого**

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

2013-2015 онуудад НЭМ-ийн чиглэлээр 239 магистрант элссэнээс 64 магистр хамгаалсан. /28 хувь/ байна. Харин докторын сургалтанд НЭМ-ийн чиглэлээр 2012 онд 12, 2013 онд 22, 2014 онд 17, 2015 оны 11 нийт 62 докторант суралцаж байна. НЭМ-ийн мэргэшүүлэх сургалтаар 2012 онд 11, 2013 онд 17, 2014 онд 17, 2015 онд 15 нийт 60 мэргэжилтэн мэргэшүүлэх сургалтыг амжилттай дүүргэжээ. Төгсөлтийн дараах сургалтаар 13 чиглэлээр урт, богино хугацааны сургалт зохион байгуулж 1000 гаруй хүнийг хамруулжээ. Төгсөлтийн сургалтанд элсэгчдийн тоо болон төгсөлтийн хувь жил бүр нэмэгдэж байна. Төгсөлтийн дараах сургалтын цар хүрээг өргөжүүлэх, суралцагч нэг бүрт хүрч үйлчлэх, сургалтын чанарыг сайжруулж, сургалтын чиглэлийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

**Зөвлөмж:**

1. Магистрын хамгаалалтын хувийг нэмэгдүүлэх
2. Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад анхаарах
3. Сургалтын хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх үйл ажиллагаа тогтмол зохион байгуулагддаг бөгөөд уг үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийн хувийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах хэрэгтэй.

### **3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа**

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

НЭМС нь Глобал сан, АХБ, НҮБ-ХАС, ДЭМБ, МСС, Мичиганы Их Сургууль, Саймон Фрейзер Их Сургууль, Өмнөд Калифорни Их сургууль, Йонсей Их сургуультай хамтарч 20 төсөлт судалгааны ажил хэрэгжүүлсэн, төслийн үр дүнг олон нийтэд тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэлбэрээр хүргэдэг байна.



Соросын сангаас “НЭМС-ийн хөтөлбөрийг хөгжүүлэх” төсөлд шалгаран 2 багш хамрагдсан. Урт хугацаагаар Тайвань, АНУ, Япон, Итали, Финланд, Өмнөд Солонгос улсын их, дээд сургуулиудад 5 багш докторын, 6 багш магистрын зэрэг хамгаалсан. Нийт 43 багш богино хугацааны сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан. 2012-2015 онуудад олон улсын байгууллагатай хамтарч 6 хурал, зочны цуврал лекц 5 зохион байгуулсан байна.

Олон улсын хамтын ажиллагаа жил ирэх бүр нэмэгдэж байгаа, олон улсын их дээд сургуулиудтай хамтарсан төсөлт судалгааны ажлыг тасралтгүй үргэлжлүүлсэнээр багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадвар сайжирч байгаа төдийгүй гадаад хэлний мэдлэг сайжирч байна.

**Зөвлөмж:**

Бакалаврын оюутны хэлний чадавхийг үнэлэх, тэднийг олон улсын оюутан солилцооны хөтөлбөрт хамруулахад дэмжих

### **3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

МХЕГ, НМХГ, ЗӨСҮТ, Хөдөлмөрийн нөхцөл, Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Байгаль орчны төв лаборатори, Ус сувгийн удирдах газар, Нийслэлийн захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын менежментийн газар, Нийслэлийн барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар зэрэг байгууллагуудтай мэргэжлийн хүрээнд нягт хамтран ажилладаг бөгөөд оюутнууд танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийх, дадлага ба семинарын хичээл орох, байгууллагын үйл ажиллагаатай танилцах аялал хийж, хамтран судалгааны ажил болон төсөлт ажил хийж гүйцэтгэдэг байна.

Монголын Орчин ба Хөдөлмөрийн эрүүл мэндийн нийгэмлэг, ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо, Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг.

НЭМС-ийн дотоод хамтын ажиллагаа сүүлийн таван жилийн байдлаар сургалт, эрдэм шинжилгээ, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлүүдээр өргөжин хөгжиж иржээ.

**Зөвлөмж:**

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааны хүрээ болон чиглэлийг улам нэмэгдүүлэх, ялангуяа хүн амын эрсдэл өндөр бүлгүүдэд чиглэсэн эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

### **3.6 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

## Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Дүгнэлт:

НЭМ-ийн сургууль нь 2014 оноос эхлэн төсөв санхүүгийн хувьд бие дааж, төсвийн нийт зардал 2016 онд 2014 оныхоос 2.5 дахин буюу 153 хувиар өссөн байна. 2014, 2015 онд нэг оюутанд зарцуулах хичээл практик болон ном хэвлэлийн зардал 2.4 хувиар өссөн байна. Мөн оюутны нэг удаагийн тэтгэмж урамшуулал 0,2-1,0 хувь болж өссөн байна.

№	Зардлын ангиллын нэр	2014 он	2015 он	2016 он
	Нийт зардлын дүн	414,771,700	833,586,206	1,048,882,800

2016 сургалтын төлбөрийн задаргааг авч үзвэл сургалтын төлбөрийн 71 хувь нь багш ажилчдын цалин хөлс, 13 хувь нь оюутанд зарцуулах хичээл практик, ном хэвлэл, оюутны зөвлөл болон оюутны нэг удаагийн тэтгэмж урамшуулалт зарцуулагдсан байна.

НЭМС-ийн төсвийн уламжлалт бус эх үүсвэрд багш нарын хичээл нөхөлтийн орлогын 50%, төслийн 10%, кредитийн сургалтын 10%, мөн НЭМ-ийн сургууль дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа төв болон лабораторийн орлогуудаас бүрдүүлж авдаг. 2014-2015 онуудад төсвийн уламжлалт бус эх үүсвэрүүдийг бүрдүүлэн Хөдөлмөр, Орчны эрүүл ахуйн лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах, номын сангийн фондыг аривжуулах, оюутанд тэтгэлэг олгох зэрэгт хувиарласан байна

№	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2014 он	2015 он	2016 он
	Нийт орлогын дүн	35,715,893	83,000,000	68,000,000

2014-2015 онуудад дараах төсвийн уламжлалт бус эх үүсвэрүүдийг бүрдүүлэн, хувиарласан байна. Үүнд:

1. Хөдөлмөр, Орчны эрүүл ахуйн лабораторид 18709 доллар багаж төхөөрөмж худалдан авч суурилуулсан 2014 онд НЭМ судлалчийн ангийн 2 оюутан Йонсей нэрэмжит тэтгэлэг болон Солонгосын профессорын нийт \$500 тэтгэлэгт тус тус хамрагдсан.
2. 2014 онд сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор нийт 16 ширхэг \$16970-ийн өртөг бүхий тоног төхөөрөмжүүдийг сургалтанд ашиглаж байна.
3. 2014 онд Хөдөлмөр, Орчны эрүүл ахуйн лабораторид **268,000,000** төгрөг багаж төхөөрөмж худалдан авч суурилуулсан.
4. 2015 онд АШУҮИС-ийн Төв номын сангийн нээлтийг тохиолдуулан оюутнуудын номын хэрэгцээг хангахын тулд номын сангийн фондыг арвижуулан нийт **2,085,000** төгрөгийн номыг хандивласан.

### Зөвлөмж:

НЭМС төсөв санхүүгийн хувьд харьцангуй бие даасан байдалтай байгаа боловч оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

## 3-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **4.1 Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

##### **Дүгнэлт:**

Суралцагч элсүүлэхдээ Нийгмийн эрүүл мэнд бакалаврын ангид суралцагчийн цогц чадамжийг 8 хүрээгээр тодорхойлон элсэлтийн журамд тусган ажиллажээ. Сүүлийн 5 жилийн дунджаас харахад элсэлтийн шалгалтын дундаж оноо хими-650.9 буюу 800 оноо авсан 22 (1.47%), 700-с дээш оноо авсан 416 (27.55%) байгаа бол биологийн дундаж оноо нь 648.1 буюу 800 оноо авсан 18 (1.19%), 700-с дээш оноо авсан 390 (25.83%)-тай байсан байна. Сүүлийн жилүүдэд АШУҮИС-д элсэхээр шалгалт өгсөн хүмүүсээс өндөр оноотой хүүхдүүд НЭМ-ийн ангийг илүү сонгосон байгаа нь АШУҮИС-д элссэн ерөнхий дүнгээс харагдаж байгаа бөгөөд энэ нь тухайн мэргэжлийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Оюутны алба нь жил бүр ЭЕШ-ын оноог эмхэтгэн тайлан бичиж, үзүүлэлтийг өмнөх гурван жилийн ЭЕШ-ын оноотой харьцуулан энэ жил элссэн сурагчдын онцлог, тэдний давуу тал, дутагдалтай талыг илрүүлэхэд нотолгоо болгодог байна. Жилд 10000 хүүхэд элсэлтийн шалгалтанд орж үүнээс 1.5% нь шалгуур ханган элсдэг.

Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо дутсанаас сургуульд элсэж чадаагүй болон жилийн чөлөө авах, шилжин суралцах оюутнуудын хүсэлтийг хүлээн авч сургалтын үйл ажиллагаанд мөрдлөг болгодог журмын дагуу шийдвэрлэж хэвшсэн байна.

Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх хичээл буюу “Удиртгал” 7 хоногийн хичээлийг АШУҮИС-ийн Оюутны албанаас 8-р сард багтаан зохион байгуулж, мэргэжлийн чиг баримжаа олгох, ёс зүй, харилцаа хандлага, сургуулийн дотоод журам, хичээлийн хөтөлбөр, программын онцлог талууд зэрэг суралахад зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг өгч бүх элсэгчдэд сургалтын хөтөлбөр болон сургалттай холбоотой дүрэм, журмыг гарын авлага болгон үнэ төлбөргүй олгодог байна.

##### **Зөвлөмж:**

1. Цаашид хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их, дээд сургуулиудад оюутан солилцооны тоогоо нэмэгдүүлэх
2. Оюутнуудаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадварыг нь сайжруулж, улсын болон олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад оролцож өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах

## **4.2 Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

НЭМС нь дөрвөн тэнхим, дөрвөн нэгжтэйгээр 16 баг оюутанд суралцах болон судалгаа шинжилгээний ажлын ур чадвар зэмшихэд нь зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжлийн баримжаа олгох, оюутныг хөгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч явуулдаг байна.

АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас оюутнуудад зориулсан “Ёс зүй, хүмүүнлэг харилцаа” сэдэвт профессоруудын цуврал лекцийг жил бүр зохион байгуулдаг ба оюутнуудын дунд ёс зүйг төлөвшүүлэх зорилгоор тогтмол тэмцээн, аяныг зохион байгуулж ирсэн байна. Үүнд: өөр хоорондоо, нийгэмд, үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах, харилцааны ур чадвар, өөрийгөө зөв илэрхийлэх арга замууд зэрэг бие хүний төлөвшлийг бэхжүүлэх ажлууд байнга зохион байгуулж нийт суралцаж буй оюутнуудын 70-аас доошгүй хувийг хамруулж хэвшжээ. Оюутнууд болон сургуулийн оюутны байгууллагаас суралцагчдын дунд зохион байгуулагдаж буй аливаа ажлыг цаг тухайд нь зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

Жил бүрийн 9-11 сард сургуулийн арга зүйч, төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаар судлагааг онлайнгаар төгсөгчдөөс болон эрүүл мэндийн байгууллагатай албан журмаар холбогдон төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдалд судалгаа хийж, түүний үр дүнд тулгуурлан дараагийн жилийн төгсөгчидтэй хийх ажлын төлөвлөгөөнд тусгаж ажиллаж иржээ. 2016 оны байдлыг авч үзвэл 2016 оны хавар НЭМ-ийн ангийг 31 оюутан төгссөнөөс төгсөгчдийн 13(41.9%) нь мэргэжлээрээ ажил эрхэлж, 4 нь магистрын сургалтанд, 5 нь жирэмсэн болон бага насны хүүхэдтэй, 9 нь ажил эрхлээгүй гэсэн судалгааны дүн гарчээ.

“НЭМС-ийн оюутны эрдмийн чуулган” нь оюутнуудыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд идэвхитэй оролцуулж судалгааны арга барил эзэмшүүлэх, цаашид мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил хийхэд нь чиглүүлэх зорилготой. НЭМС-ийн оюутны эрдмийн чуулганд оюутан өөрийн хүсэлтээр сэдэв, удирдагч багшийг чөлөөтэй сонгон оролцох боломжтой байна. НЭМС-ийн багш, оюутнууд судалгааны ажилд идэвхитэй оролцдог ба, жилд дунджаар 7 багшийн удирдсан 16 судалгааны баг оролцдог байна. Нэг багш дунджаар 2 судалгааны баг, хамгийн ихдээ 4 баг удирдсан байна.

## **4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг**

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **Дүгнэлт:**

АШУҮИС-ийн Оюутны албаар дамжуулан сургуульд шинээр элсэж байгаа оюутнуудыг бүртгэн хүлээж авахаас эхлэн сургууль төгсөх хүртэлх бүх үйл ажиллагааг зохицуулан нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг байна.

Суралцагчдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн илрүүлэх, тэдэнд судалгаа, эрдэм шинжилгээний ажлын талаар суурь мэдлэг, мэдээлэл олгох, Оюутан залуус, дунд сургуулийн суралцагч, нийгэмд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн тулгамдаж буй асуудлаар сургалт, сурталчилгаа явуулах ажлуудыг тогтвортой зохион байгуулж иржээ. Тухайлбал: Жил бүр НЭМС-ийн урлаг спортын наадмыг зохион байгуулахад НЭМС-ийн захиргаа заал танхимаар ханган ажилладаг байна.

АШУҮИС нь оюутны байгууллагын зохион байгуулж байгаа урлаг, спорт, нийтийг хамарсан үйл ажиллагаа, төгсөлтийн баяр болон оюутны байгууллагын бичиг хэргийн зардалд санхүүгийн дэмжлэг туслалцааг тогтмол үзүүлж иржээ. Үүнд санхүүгийн дэмжлэг 2013 онд 2,2 сая байсан бол 2016 онд 7,2 сая болж өссөн байна.

Сургуулийн захиргаанаас оюутны байгууллагаас санаачилсан мэргэжлийн болон спортын уралдаан тэмцээн, урьдчилан сэргийлэх үзлэг, нийгмийн эрүүл мэндийн ухуулга нөлөөллийн ажил зэрэг олон талт ажлуудад байнга дэмжүүлэг үзүүлж, зарцуулах санхүүжилтийг сүүлийн 3 жилд өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлж ажилласан байна.

### **4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо**

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

## **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Дүгнэлт:**

АШУҮИС, НЭМС-ийн зүгээс сурлага, урлаг болон спортын өндөр амжилт гаргасан, олон нийтийн ажилд идэвхитэй оролцдог оюутныг урамшуулан дэмжих зорилгоор төрөл бүрийн тэтгэлэг олгох, хөнгөлөлт үзүүлэх, салбарын тэргүүний оюутныг шалгаруулах ажлуудыг тогтмол хийж оюутнуудыг өөрийн сургуулийн болон бусад тэтгэлгүүдэд хамруулах ажлыг зохион байгуулснаар 2011–2012 оны хичээлийн жилд 14 оюутан тэтгэлэгт, 11 оюутан солилцоо болон зуны дадлагад гадаадад хамрагдаж, 2012–2013 оны хичээлийн жилд 8 оюутан тэтгэлэгт хамрагдаж, БНСУ болон Итали улсад 3 оюутан солилцоогоор суралцсан бол 2013–2014 оны хичээлийн жилд 9 оюутан тэтгэлэгт хамрагдаж, АНУ-ын 2 оюутан НЭМС-д мэдээлэл цуглуулах ажлаар 3 сар суралцах хугацаандаа НЭМС-ийн оюутнуудад англи хэлний мэдлэгийг сайжруулах зорилгоор хичээл зааж, өөрсдийн туршлагаасаа хуваалцах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

2014–2015 оны хичээлийн жилд 8 оюутан тэтгэлэгт хамрагдаж, оюутан солилцоогоор 1 оюутан БНСУ-д суралцсан бол Япон улсаас 7 оюутан НЭМС-д 14 хоногийн хугацаатай суралцсан байна.

2015–2016 оны хичээлийн жилд давхардсан тоогоор 26 оюутан захирлын нэрэмжит болон дотоод аж ахуйн нэгж, гадаадын сургуулийн болон профессор багшийн нэрэмжит тэтгэлгийг тус тус хүртжээ.

### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэдлэг, чадварыг улам нэмэгдүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөхүйц мэргэжилтэн бэлтгэгдэх нөхцлийг сайжруулж гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, гадаадын их, дээд сургуулиудад оюутан солилцооны тоогоо нэмэгдүүлэхэд анхаарах,
2. Оюутнуудыг олон улсын эрдэм шинжилгээний ажилд оролцох чадвар, боломжийг сайжруулах.

#### **4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

### **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Дүгнэлт:**

Оюутны шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС–ийн оюутны шилжилт хөдөлгөөний дүрэм журмын дагуу зохицуулдаг ба Монгол Улсын Боловсролын тухай хуулинд заасан аливаа хүн нас, хүйс, арьс өнгө, хэл соёл, шашин шүтлэг харгалзахгүй сурч боловсрох эрхтэй гэсэн үзэл баримтлалыг мөрдөн ажилладаг байна. Сүүлийн 5 жилд 230 гаруй оюутны шилжих хөдөлгөөнийг дээрхи журмын дагуу зохицуулж ажиллажээ.

Оюутны шилжилт хөдөлгөөнийг шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, нөхцөл байдлаар тодорхойлж, ямар тохиолдолд шилжих хөдөлгөөнийг хэрхэн зохион байгуулах талаар “Оюутны шилжих хөдөлгөөнийг зохицуулах журам”-д тусган, суралцагчийн хувь хүний эрхийг эрхэмлэн, хүндэтгэх зарчмыг баримтлан шийдвэрлэж ирсэн байна.

Шилжих хөдөлгөөнд гадаадын их дээд сургуульд сургалтын хөтөлбөрийн багц цагийн зөрүүг нөхөн, шилжин суралцах асуудал багагүй хэмжээг эзэлж ирсэн байна. Энэ нь тус сургуулийн хөтөлбөр Олон улсад хүлээн зөвшөөрөгдөж буйн нэг баталгаа юмаа гэж үзэж болох юм

2011 – 2016 оны хичээлийн жилүүдэд АШУҮИС–ийн захирлын тушаалаар гадаад болон дотоодын их дээд, салбар сургуулиас 12 оюутан шилжин ирж суралцаж, мөн 39 оюутан мэргэжлийн чиглэлээ сольж шилжин суралцсан байна.

#### **Зөвлөмж:**

Шилжилт хөдөлгөөнд хувийн болон хөтөлбөрийг хангахгүй байдлаас чөлөөлөгдөх, хасагдах шалтгааны эзлэх хувийг тодорхойлж, шаардлагатай бол шалтгаан болж буй үзүүлэлтийг багасгах, элсэлтийн шалгуурт тодорхой заалт бий болгон ажиллах шаардлагатай.

### **4-р бүлгийн шинжээчийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

Багшийн сонгон шалгаруулалтанд Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, эдгээртэй нийцүүлсэн АШУУИС-ийн Багш сонгон шалгаруулж авах, багшлах эрх олгох журмыг мөрдөж байна. Шинээр багш ажилд авах ажлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхэм, сургуулийн саналыг үндэслэн дээрх зохицуулалтын дагуу АШУУИС-ийн СБЗГ, Багш сонгон шалгуурлах зөвлөл зохион байгуулж байна.

2014 онд АШУУИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газрын дэргэд байгуулагдсан “Багшийн хөгжлийн төв” нь шинээр ажилд орсон багш нарыг “Анагаахын боловсрол судлал” сургалтанд хамруулж сурган заах арга барилд сургадаг.

2014 онд НЭМС-ийн багш нарын 38.4.8% доктор зэрэгтэй байсан бол 2016 онд 51% болж нэмэгджээ. Энэ нь БСШУС-ын 2010 оны 26 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 3.3-д заасан үндсэн багшийн 15-аас доошгүй хувийг докторын зэрэгтэй байна гэсэн шаардлагыг хангаж байна

АШУУИС-ийн багшийг хөгжүүлэх тулгуур баримт бичиг, АШУУИС-ийн боловсон хүчний нэгдсэн бодлогын хүрээнд их сургууль, бүрэлдэхүүн сургууль, тэнхим, хувь хүний түвшинд багшийн сургалт зохион байгуулах, эрдэм шинжилгээ, мэргэжлийн мэдлэг ур чадварыг хөгжүүлж байна.

Сургалтын чанарыг сайжруулах, нэг багшид оногдох оюутны тоог бууруулж олон улсын жишигт хүргэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. 2014 онд нэг багшид 21 оюутан оногдож байсан бол 2016 онд 19 болсон бөгөөд 2024 онд 12 болгох зорилт тавьжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багш нарын албан тушаалын зэрэглэлийн ангилалд АШУУИС-ийн Багш хөгжүүлэх тулгуур баримт бичиг, Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, Аттестатчлалын журам, Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлдэг багш нарын ажлыг гүйцэтгэлд суурилан үнэлдэг тогтолцоо АШУУИС дээр хэрэгжиж байна. Үүнд АШУУИС-ийн дотоод журам, Багшийн алтан дүрэм, Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг МУ-ын Хөдөлмөрийн тухай хууль бусад хууль тогтоомжтой нийцүүлэн ашиглаж байна.

#### **Зөвлөмж:**

Багшийг сонгон шалгаруулахдаа эрдмийн зэрэг цол, хэлний мэдлэгээс гадна харилцаа, хандлага, практик ажлын туршлагыг харгалзах

## 5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Дүгнэлт:**

АШУҮИС-ийн багш нарын тасралтгүй хөгжих үйл ажиллагааг дэмжих, боловсролын судалгааны арга зүй эзэмшүүлэх, сурган заах арга зүйн орчин үеийн ойлголт, мэдлэгийг амьдралд хэрэгжүүлэх, үр дүнг тооцох зорилготойгоор 2014 онд СБЗГ-ын дэргэд “Багшийн хөгжлийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг тогтмол явуулж байна. АШУҮИС-д шинээр ажилд орсон багш бүр “Анагаах ухааны боловсрол судлал” сургалтанд зайлшгүй хамрагддаг. Мөн СБЗГазар багш нарт орчин үеийн боловсрол судлалын талаар сурган заах шаардлага байгаа гэж үзэн 2008 оноос эхлэн “Асуудалд суурилсан сургалтын (PBL) тугор бэлтгэх” нийт 12 удаагийн сургалтыг явуулсан. Багш хөгжлийн хөтөлбөрт тусгасан боловсрол судлалын сургалтанд НЭМС-аас 2012 онд 3, 2013 онд 4, 2014 онд 11, 2015 онд 4, 2016 онд 3 багш хамрагдсан байна.

- **2011 онд:** Япон, АНУ, Итали, Турк, Герман улсад болсон урт болон богино хугацааны 6 сургалтанд давхардсан тоогоор НЭМС-ийн 8 багш хамрагдсан байна. Дотоодын 34 сургалтанд давхардсан тоогоор нийт 45 багш хамрагдсан.
- **2012 онд:** Итали, АНУ, Япон Унгар, БНХАУ-д зохион байгуулагдсан 8 сургалтанд 9 багш хамрагдсан.
- **2013 онд:** АНУ-д 6 сургалтанд 8 багш суусан. Дотоодын 12 сургалтанд 28 багш хамрагдсан байна.
- **2014 онд:** БНХАУ, Солонгос, АНУ-д зохион байгуулагдсан 10 сургалтанд 10 багш хамрагдсан бол дотоодод зохион байгуулагдсан 11 сургалтанд 28 багш хамрагджээ.
- **2015 онд:** БНХАУ, Хонг Конг, Вьетнам, АНУ-д зохиосон 6 сургалтанд 8 багш хамрагдсан байна. Дотоодын нийт 51 сургалтанд давхардсан тоогоор 74 багш хамрагджээ.

НЭМС-ийн багш нарын дунд докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь 2012-2016 оны хугацаанд 8.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. НЭМС-ийн багш нарын эрдмийн зэрэг хамгаалалт нэмэгдэж энэ тоо 2012-2016 онд 8.2 хувиар нэмэгдсэн байна. Түүнчлэн НЭМС-ийн эрдэмтэн багш нарын эзлэх хувь АШУҮИС-ийн 2015-2024 оны хөгжлийн хөтөлбөрт заасан их сургуулийн эрдэмтэн багш нарын эзлэх хувиас өндөр үзүүлэлттэй байна.

### **Зөвлөмж:**

Сургуулийн гадаад харилцаа сайн хөгжин, багшийг судалгаанд суурилсан хөтөлбөрөөр чадавхжуулан гадны өндөр хөгжилтэй оронд суралцуулж байгаа учраас сурч ирсэний дараа тодорхой төлөвлөгөөтэй ажиллах, сурсан зүйлээ практикт, сургалт, эрдэм шинжилгээнд ашиглахад хяналт тавин ажиллах



### 5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

НЭМС сүүлийн 5 жилийн хугацаанд улсын хэмжээнд БОНХЯ, ЭМЯ-ны захиалгаар 1 төсөл хөтөлбөр, олон улсын томоохон сургуулиуд болон ДЭМБ гэх мэт байгууллагуудтай хамтран 6 төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байна.

Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхийг эрчимжүүлэх, дэмжих зорилгоор Томсон Ройтерсийн индекс (IF) бүхий олон улсын сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор судалгааны ажил хэвлүүлсэн 1 багш урамшуулал авсан ба НЭМС-ийн ОЭМТ-ийн зочин профессор Др. Меридит Прамсма 2014-2016 оны хооронд нийт 30 гаруй журнал клубийг сургуулийн нийт багш нарын дунд англи хэл дээр явуулан багш эрдэмтдийн бичсэн судалгаа шинжилгээний ажлыг англи хэл дээр хянасан. Нийгмийн эрүүл мэндийн ЭРИН сэтгүүлийг улирал тутамд хэвлүүлэн гаргадаг нь нийгмийн эрүүл мэндийн салбарын хүрээнд хийгдэж буй судалгаа шинжилгээний голлох бүтээлийн эмхэтгэл болж байна.

Олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, ишлэгдсэн байдлаар нь НЭМС багш нарын 37% хувь нь Research Gates болон Google Scholar-д тус тус өөрийн гэсэн мэдээллийг оруулсан судалгааны өгүүллүүд нь бүртгэгдсэн байна. АШУҮИС нь судалгаанд суурилсан, Ази номхон далайн баруун эргийн шилдэг 100 их сургуулийн нэг болох зорилготойгоор судалгаа, сургалт, эрүүл мэндийн үйлчилгээг цогцоор нь хөгжүүлдэг энтрепренёр корпорацийн үзэл баримтлалтай, санхүүгийн хувьд бие даасан, тогтвортой их сургууль болон хөгжиж байна. Үүнд НЭМС нь Нийгмийн эрүүл мэндийн салбарын судалгаа шинжилгээний чиг хандлагыг тодорхойлогч байгууллага болж үндэсний болон олон улсын хэмжээний томоохон судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

**Зөвлөмж:**

- НЭМ-ийн тусламж үйлчилгээний хүртээмж, түүний чанар өгөөж, хэрэгцээний талаарх судалгаагаар ЭШ-ний чиглэлээ өргөтгөхөд цаашид анхаарах

### 5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

Багш нар өөрийн үнэлгээний тайланг, нотлох баримтын хамт бүрдүүлэн багш хөгжүүлэх төвд хүргүүлдэг. 2013-2016 онуудад НЭМС-ийн нийт 40 багш аттестатчлалд орж багш

нарын 65% нь ажлын гүйцэтгэл, үр дүн сайн, 30% нь ажлын гүйцэтгэл, үр дүн дунд зэрэг, 5% нь хангалтгүй гэж үнэлэгдсэн байна. НЭМС-ийн нийт багш нарын албан тушаалын зэрэглэл 2016 оны байдлаар дадлагажигч багш 27.9%, багш 30.2%, ахлах багш 30.2%, дэд профессор 6.97%, профессор 4.65% бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Ахлах багшийн тоо 2013 оноос нэмэгдэж ирсэн байна. НЭМС-ийн нийт багш нарын хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн хурлыг жилд 2 удаа зохион байгуулж, тэнхмийн эрхлэгч нар тэнхмийн ажлын тайланг, мөн жилийн эцсийн хурлаар тэнхим бүрээс шалгарсан шилдэг багшийн ажлын тайланг танилцуулан хэлэлцүүлж, санал дүгнэлтээ өгч, ажлын гүйцэтгэлийг үнэлдэг байна.

2011-2015 онуудын АШУҮИС, НЭМС-ийн “Эрдмийн чуулган-53-57” зохион байгуулсан ба нийт 280 гаруй бүтээл ирснээс 205 буюу 73.2% нь НЭМС-ийн багш нарын бүтээл байна. Сүүлийн 3 жилийн байдлаар НЭМС-ийн Эрдэмтдийн Зөвлөлийн хурлаар докторын явцын хэлэлцүүлэг 17, магистрын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалт 66, судалгааны ажлын аргачлал, үр дүнгийн хэлэлцүүлэг 15 асуудлыг тус тус хэлэлцэж, санал, шүүмж, зөвлөмжийг өгч, ажлыг сайжруулж, чанаржуулсан байна.

Нийт багш нарын зааж буй хичээл бүрээр оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг. Заах арга зүй, үнэлгээ, харилцаа хандлагын үнэлгээгээр оюутнуудын өгсөн онооны дундаж 4.1 (нийт авбал зохих оноо 5) байна.

НЭМС-ийн Захиргаанаас дадлагажигч 13 багшийн ажлын хавтсын бүрдүүлэлтийг Багш нарын хичээлийн файлын бүрдлийн үнэлгээгээр үнэлэхэд үнэлгээнд хамрагдсан багш нарын 4 багш “В”, 4 багш “С”, 2 багш “D” үлдсэн багш хангалтгүй үнэлэгджээ. Багш нарыг хичээлийн файлын бүрдүүлэлтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон байна.

### **Зөвлөмж:**

Сургалтанд хамрагдсан багш нарын заах арга зүйн үр дүн, үр нөлөөний судалгааг хийж хэвшүүлэх хэрэгтэй байна. Аттестатчлалд А үнэлгээ авсан багш нарыг урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

**5-р шалгуурын шинжээчийн нэгдсэн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **Шалгуур 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **Дүгнэлт:**

- Хэрэгцээ шаардлагыг судлан шинжилсний үндсэн дээр шаардлагатай зарим хичээлийг нэмж, заримыг хасч, хичээлийн хөтөлбөрүүдийн агуулга болон заах аргыг дадлага, семинарыг нэмэгдүүлэх, харилцаа, багаар ажиллах чадвар эзэмшүүлэх, зуны дадлагын чанарыг сайжруулахад чиглүүлэн өөрчилж, шинэчилсэн.
- Хөтөлбөрийн үр дүнг НЭМ-ийн мэргэжилтний эзэмшвэл зохих цогц чадамжаар тодорхойлж, түүнд нийцүүлэн хичээлийн хөтөлбөрүүдийн агуулгыг шинэчилсэн.
- Хөтөлбөрийн нийт багц цаг 165, түүний 28.3%-ийг Ерөнхий суурь хичээл (47 багц цаг), 22.9%-ийг мэргэжлийн суурь хичээл (38 багц цаг), 48.2%-ийг мэргэшүүлэх хичээл (80 багц цаг) эзэлж байна.
- Хичээлийн танхимд онол, семинарын хичээлийг явуулдаг бол өөрийн сургуулийн лабораториуд, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон түүний лабораторид дадлагын хичээлийг явуулдаг.
- Хөтөлбөрийн багтаамжийн 7.3%-ийг сонгон суралцах хичээл эзэлдэг.
- Зайн сургалтын төв, Төв номын сан, Судалгааны арга зүйн ба Эрүүл мэндийн бодлогын төвүүдэд E- сургалтын орчин, тоног төхөөрөмжтэй болж цахим сургалтын төв, мультимедиа студ(тусгай дуу, дүрс бичлэг ашиглах)-тэйболсон.
- Цахим сургалтын сан бүрдүүлэх ажил хийгдэж, ерөнхий суурь, сонгон суралцах хичээлийн лекцийг100% нь цахим хэлбэрт шилжсэн. Бусад хичээл бүрийн лекцийн 25%-ийг онлайн хэлбэрт шилжүүлэх ажил эхлэн явагдаж байгаа.
- 2016 онд шинэчлэн Сургалтын бодлого зохицуулалтын албаар батлуулсан хөтөлбөрийн багтаамж, онол, дадлагын хичээлийн эзлэх хувь зэрэг нь "Дээд боловсролын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах шаардлага"-ыг хангасан.

## **Зөвлөмж:**

Төгсөлтийн болон явцын шалгалтанд цогц чадамжид тусгасан ур чадварыг эзэмшсэн эсэх дээр үнэлэн дүгнэхэд анхаарах

### **6.2. Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

## **Шинжээчийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Дүгнэлт:**

- БСШУЯ-ны сайдын А174-р тушаалд заасан хичээлийн хөтөлбөрийн бүтэц, агуулгын талаарх заалтуудад үндэслэн АШУҮИС-ийн СБЗГ-аас боловсруулсан хичээлийн хөтөлбөрийн загвараар хичээлийн хөтөлбөрийг багш нарын баг боловсруулж, тэнхмийн эрхлэгч хянан, бүрэлдэхүүн сургуулийн захирал болон АШУҮИС-ийн СБЗГ-ын дарга баталгаажуулдаг. Мөн хөтөлбөрийг боловсруулах явцад СБЗГ-ын мэргэжилтнүүд арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилладаг. 88 хичээлийн хөтөлбөр батлагдсан.

- Дадлага, семинарыг судалгааны арга зүйн төв, компьютерийн лаборатори, хүнсний эрүүл ахуйн лаборатори, хөдөлмөр, орчны эрүүл ахуйн лабораторийг түшиглэн явуулдаг. Лабораторид дадлага хийх хичээл бүрийн удирдамжийг боловсруулсан. Хөтөлбөрт оюутны бие даалтын цагийг нэмэгдүүлсэн
- АШУҮИС-ийн захирлын 2016.11.09-ны А/118 тоот тушаалын 2-р хавсралтаар баталсан “АШУҮИС-д цахим сургалт эрхлэх журам” батлагдан мөрдөгдөж байгаа. Цахим сургалтын төв, мултимедиа студийг ашиглан цахим сургалтын сан бүрдүүлэх ажил хийгдэж байна.
- Мөн АШУҮИС дээр оюутны хэрэгцээнд нийцүүлэн интернет төвүүд, e-номын сан, багаар ажиллах зориулалт бүхий орчин бүрдүүлсэн. НЭМС-ийн орчинд wireless internet-г суурилуулсан. Дэлхийн хамгийн том биоанагаахын болон эрүүл мэндийн ном зохиолуудыг олж авах мэргэжлийн мэдээллийн <http://www.who.int/hinar-r> ашиглах боломжтой.

#### **Зөвлөмж:**

Өрхийн болон анхан шатны ЭМ-ийн тусламж үзүүлдэг байгууллага дээр дадлага хийх хугацааг цаашид нэмэгдүүлэх

### **6.3. Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэхдээ БСШУ-ны сайдын А174-р тушаал, АШУҮИС-ийн захирлын 2015.12.15 А/144 тушаалаар тус тус батлагдсан журмуудыг баримталдаг, хичээл бүрийн агуулга, онцлогт тохируулан олон арга, хэлбэрүүдээс тохиромжтойг нь сонгох, нэг хичээлд олон арга зүйг хослуулан үнэлэхээр хичээлийн хөтөлбөрт тусгасан.
- Сургуулийн нэгдсэн программыг ашиглан <http://elearning.mnums.edu.mn/-p> ерөнхий суурь 5 хичээл, мэргэжлийн суурь 1 хичээл, төгсөлтийн шалгалтыг авдаг.
- Энэ хүрээнд Их сургуулийн удирдлага мэдээллийн систем UNIMIS (CLOUD UNIVERSITY)–г (2015 оноос) нэвтрүүлэн оюутны мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх болсноор үнэлгээ ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байна.
- Сурлага, эрдэм шинжилгээний судалгаа, урлагийн чиглэлээр гаргасан амжилт бүтээлтэй оюутнууд цөөнгүй байгаа нь НЭМ-ийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн үр дүнг батлах нэгэн нотолгоо болж байна.

#### **Зөвлөмж:**

Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг нэмэгдүүлэх

**6-р шалгуурын шинжээчийн эцсийн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ**

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна

### **7.1 Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

АШУУИС-ийн НЭМС-ийн Нийгмийн эрүүл мэндийн ангийг 2012-2016 онуудад нийт 130 хүн сурч төгссөн байна. НЭМС-ийн НЭМ судлалч хөтөлбөрийг 2012-2016 онд төгссөн бөгөөд сургуулиас сүүлийн 5 жилд жил бүр төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг хийж иржээ. Сүүлийн 5 жилд хийгдсэн судалгааны дундаж дүнгээс харахад төгсөгчдийн 67% мэргэжлээрээ, 32% гадаад болон дотоодын их дээд сургуулийн төгсөлтийн дараах сургалтанд хамрагдаж байгаа ба 18% одоогоор ажил эрхлээгүй (энэ дүнд жирэмсэн, төрөөд хүүхдээ гэртээ харж байгаа хүмүүс хамрагдсан байна) гэсэн судлагааны дүн гарсан байна.

Тус сургуулиас 2012 - 2016 онуудад хойш төгсөгчдийн ажил эрхлэлтийн болон ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлсэн байна. Энэхүү судалгааг хийхдээ ажил олгогч төгсөгчдийн төлөөллийг хамруулж, 1-3 жил ажилласан ажлын үр дүнг чанарын болон тооны судалгааны аргаар тодорхойлсон байна.

Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг хийхдээ төгсөгч нэг бүрийг, судалгаанд цахимаар хамруулдаг нь төгсөгчдөд илгээсэн цахим шуудан, төгсөгчдийн төлөөлөлтэй уулзсан ярилцлагаар баталгаажиж байна.

Төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцлийн судалгааг жил бүрэн явуулж хэвшсэн бөгөөд судалгааны үр дүнг хөтөлбөрийн холбогдох хэсэгт тусган ажиллаж ирснээр сүүлийн 1-2 жилийн судалгааны үр дүнд нийцлээс шалтгаалсан хүндрэл багассан гэсэн үр дүн гарсан байна.

Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар онолын мэдлэг сайн эзэмшсэн байдаг тул цааш өсөн дэвших боломжтой, НЭМ-ийн чиглэлээр хэрэгжиж буй бодлогын бичиг баримт дээр ажиллахад дөхөм байдаг, багш нар нь практикийн мэдлэг олгох мэргэжлийн өндөр чадвартай байдаг гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Ажлын байраар хангагдаж буй талаар жил бүрийн хийсэн судалгааны дунджаар төгсөөд ойролцоогоор дунджаар 0.5-3 жил зарцуулдаг байна.

Ажил олгогчидтой хийсэн уулзалтаар, хөтөлбөрөөр төгсөгч нь тухайн мэргэжлийн эрэлт хэрэгцээг хангасан, салбарын ирээдүйн тогтвортой хөгжлийн гол хүчин болж буй нь тодорхойлогдсон.

#### **Зөвлөмж:**

Нийгмийн эрүүл мэнд мэргэжилтний эрэлт хэрэгцээг олон улсын аргачлалаар зөвхөн эрүүл мэндийн салбар төдийгүй бусад салбарыг хамруулсан тандалт судалгаагаар илүү нарийвчлан тогтоож, үр дүнг хөтөлбөрт тусгах

## **7.2 Хөтөлбөрийн үр нөлөө**

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:**

Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийг амжилттай дүүргэн ажиллаж буй болон дараагийн шатны сургалтанд суралцаж буй төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 5 жилд тогтмол авсан байна. Эдгээр судалгаануудад төгсөгчдөөс гадна төрийн болон төрийн бус байгууллагын ажил олгогч нарыг хамруулсан байна.

Судалгаанд оролцогсод өөрсдийнхөө эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад хир сэтгэл хангалуун байдлын талаар мөн судалгаа авч дүнг хөтөлбөрийг сайжруулахад тусгаж ажилласан бөгөөд үүнийг сургалтын бодлого зохицуулалтын газар хариуцан ажилладаг байна.

Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд нь уг хөтөлбөрийн үр нөлөөг тодорхойлох нэг үзүүлэлт болж байна. Тухайлбал: 2016 оны 6-р сарын байдлаар 2012-2016 оны төгсөгчдөөс 41 хүн буюу 32% магистрын сургалтад хамрагдсан ба 7% гадаад, 93% АШУҮИС-ийн НЭМ-ийн магистрын сургалтад суралцаж, магистрын зэргээ амжилттай хамгаалсан байна. Мөн төгсөгчид төгсөлтийн дараах богино болон урт хугацааны сургалт, магистрын сургалтанд хамрагдаж буй оюутны тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь статистик үзүүлэлтүүдээр нотлогдож байна.

Ажил олгогчдоос авсан судалгаагаар ихэнхдээ эмнэлзүйн ур чадвар сул, ЭМНА-ны ажлын байрны тодорхойлолт тодорхойгүй, эмнэл зүйн гардан үйлдлийн ур чадвар хангалтгүй, асуудал шийдвэрлэх чадвар, судалгааны төсөл бичих чадвар дутмаг, судалгааны үр дүнгийн мэдээлэл боловсруулах, үнэлгээ өгөх чадвар хангалтгүй, ЭМ-ийн талаар зөвөлгөө өгөх чадвар хангалттай бус хэмээн дүгнэсэн байна.

НЭМ-ийн мэргэжлээр төгсөгчид нь мэргэжлийн салбарын хэрэгцээг хэрхэн хангаж байгаа талаар НЭМ-ийн сургууль 2012, 2014, 2015, 2016 онуудад төгсөгчдийг ажлаар хангасан төрийн болон ТББ-ыг оролцуулсан судалгаа хийсэн байна. Уг судалгаанаас болон бидний ажил олгогч нартай хийсэн уулзалтын дүнгээс харахад уг хөтөлбөрийг төгсөгчид нийгмийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж байгаа төдийгүй ажлын байрны эрэлт хэрэгцээ их байгааг анхаарч, элсэлт, төгсөлтийн тоог нэмэх шаардлагатай байгаа нь харагдаж байлаа.

**Зөвлөмж:**

1. НЭМ-ийн мэргэжлийн онцлог, ялгаа, ач холбогдлын талаар ЭМБ-ын удирдлагуудад таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах,
2. Эмнэлгийн халдвар судлал зэрэг тодорхой чиглэлээр дадлагын төрлийг нэмэгдүүлэх,

3. Дадлага хийх байгууллагын тоо, төрлийг нэмэгдүүлэх,

### **7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

НЭМС олон улсад хамтран хэрэгжүүлдэг хөтөлбөрийн хүрээнд 2011 – 2015 онуудад 48 оюутныг гадаадын тэтгэлэгт, 26 оюутан захирлын нэрэмжит болон дотоод аж ахуйн нэгж, гадаадын сургуулийн болон профессор багшийн нэрэмжит тэтгэлэгт хамруулж, 35 оюутныг оюутан солилцоогоор АНУ, БНСУ, Итали, Япон зэрэг улсуудад суралцуулсан байна. 2011-2016 оны хугацаанд НЭМ-ийн мэргэжилтнээр суралцаж буй 16 оюутан улсын хэмжээний эрдэм шинжилгээны хурал, арга хэмжээ, тэтгэлэг, уралдаан тэмцээнд 44 шагнал, тэтгэлэг хүртэж, амжилттай суралцсан байна. Мөн НЭМС-ийн төгсөгчдөөс McGill-ийн Их сургууль, АНУ-ын Жонс Хопкинсийн НЭМС, БНХАУ-ын Бээжингийн Их сургууль, Сөүлийн Их сургууль болон Австралийн их сургуульд тус бүр 1-2 оюутан жил бүр магистр, докторын сургалтанд суралцаж байна.

Одоогийн байдлаар тус хөтөлбөрөөр гадаадын оюутан элсэн суралцаагүй байна. Сургуулийн төгсөгчдийн нилээдгүй хувь нь гадаадын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиудад төгсөлтийн дараах сургалтанд элсэн суралцсан байгаа нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж буйн нотолгоо болно.

#### **Зөвлөмж:**

1. Сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээхийлгэн суралцагчдын цогц чадамжийг үндэсний хэмжээнд болон гадаадад хүлээн зөвшөөрүүлэх ажлыг зохион байгуулах
2. Гадаад оюутан элсүүлэх боломжийг бий болгох

### **7.4 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Дүгнэлт:**

“Дээд боловсрол. Мэргэжлийн чиглэл: нийгмийн эрүүл мэнд. MNS 5323-125:2012, “НЭМ –ийн мэргэжилтэний цогц чадамж” захирлын тушаал, холбогдох ЭМ-ийн Сайдын тушаалууд, Эрүүл мэндийн зарим мэргэжлээр төгсөгчдөд тавих шаардлага,УБ, 2012, жил бүрийн тайлан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох тайлан болон сургуулийн үйл ажиллагааны баримтын цомогтой танилцахад хөдөө орон нутгуудад богино хугацааны

## 8.1 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

сургалт явуулан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн агуулгыг танилцуулан, баяжуулсан байна.

Сургуулийн цахим хуудсанд хөтөлбөр болон сургалтын талаарх мэдээллийг цахим хуудасны админ хариуцан тухайн өдөрт нь оруулж, цахим хуудасны хандалт, саналд хяналт хийж ажиллаж хэвшсэн байна.

Хөтөлбөрийг суралцагчид, сонирхогчдын хүртээл болгох нээттэй ил тод байдлыг хангаж зорилгоор [www.mnums.edu.mn](http://www.mnums.edu.mn) цахим хуудас болон БСШУЯ-ны [www.meds.gov.mn](http://www.meds.gov.mn) портал сайтаар дамжуулан, мөн сонин сэтгүүл болон бусад хэвлэл мэдээллийн сувгуудыг тогтмол ажиллуулж ирсэн байна.

НЭМ-ийн сургууль нь НЭМ-ийн хөтөлбөрийн талаар олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангахад орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилтэд хэлбэрүүдийг ашиглан, тогтвортой мэдээллээр ханган, зорилтод бүлэгт чиглэсэн олон нийтийн сүлжээг ажиллуулж хэвшсэн байна.

### **Зөвлөмж:**

1. Хөтөлбөрийг улс орны хэрэгцээнд илүү нийцүүлэх зорилгоор хэрэгцээ нийцлийн судалгааг 3 жил тутамд хийж, ажил олгогч нарт санал хүргүүлэх,
2. НЭМС-ийн НЭМ хөтөлбөрөөр гадаадаас ирж суралцах оюутнуудын тоог нэмэгдүүлэх тодорхой ажил зохион байгуулах,
3. Төгсөгчдийн мэргэжлийн салбарт хэрхэн хувь нэмэр оруулж буйд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх.

**7-р бүлгийн шинжээчийн нэгдсэн үнэлгээ:** Бүрэн хангасан

## **ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ БАТАЛГААЖИЛТ**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан

### **Дүгнэлт:**

Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол чанартай гүйцэтгэх зорилгоор жил бүр төлөвлөгөө гарган хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, дотоод чанарын баталгаажуултанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудыг оролцуулан, хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан өөрийн үнэлгээг хийж, хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоотой ажиллаж ирсэн байна.

Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах үүднээс АШУҮИС -ийн Захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний албыг сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн үр дүнд дүн шинжилгээ хийж, мэдээллээр хангах, удирдлагын шийдвэр гаргах үндэслэлийг хангах, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх үндсэн чиг үүрэгтэйгээр 2007 онд байгуулж, Захирлын 2016 оны А/15 тоот тушаалаар ерөнхий аудитор, дотоод аудитор, боловсролын чанар хариуцсан ахлах



арга зүйч, эрдэм шинжилгээний чанар хариуцсан арга зүйч, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын менежер гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 4 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалын АШУҮИС-ийн 2015 оны 10 сарын 9-ны өдөр багшийн хөгжлийн болон хөтөлбөрийн зөвлөл байгуулах тухай захирлын тушаалаар нийгмийн эрүүл мэндийн сургууль дээр НЭМ-ийн хөтөлбөрийн зөвлөлийн дарга 1, зохицуулагч 2, гишүүд 13 нийт 16 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдсан байна.

Энэхүү зөвлөлийг байгуулснаар сургуулийн нэгж бүр дотооддоо чанарыг хангах, баталгаажуулах боломж нөхцөл бүрдэж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгөх, чанарыг сайжруулах дэмжлэгт орчин бүрдсэн байна.

АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас

- төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа, дадлага, сонгон суралцах хичээл явуулах журмууд,
- сургалтын технологи, чанарын хяналт хийх үлгэрчилсэн журам,
- оюутны мэдлэгийг үнэлэх журам зэрэг нэгдсэн бодлогоор хөтөлбөрийг чанартай явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Сургалтын бодлого зохицуулалтын газар дээрх дүрэм журмын хэрэгжилтэд сар улирлаар төлөвлөгөө гарган тогтмол хяналт-үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажилладаг нь төлөвлөгөөт хяналт үнэлгээний төлөвлөгөө тайлан, хурлын тэмдэглэлүүдээр батлагдаж байна. (Үүнтэй холбоотой архивын баримт материалтай танилцлаа)

Дотоод чанарын баталгаажуултанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талууд болох багш, суралцагч, төгсөгчид, ажил олгогчдын төлөөллийг оролцуулан хийдэг бөгөөд эдгээр төлөөллийг тогтмол солих байдлаар илүү өргөн хүрээг хамарч ажилладаг байна. Ингэснээр дотоод хяналтыг хөндлөнгийн байдлаар зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллажээ.

Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж, өөрийн үнэлгээг хийдэг байдал ба хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоо үүсгэн ажилладаг байна. Үүнд: Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг “Хөтөлбөрийн хороо” үнэлэхдээ оролцогч талуудаас жил бүр сэтгэл ханамжийн үнэлгээ (төгсөгчдөөс), явцын үнэлгээ (оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ), гүйцэтгэлийн үнэлгээ (Ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ), үр нөлөөний үнэлгээ (мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх), хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ үнэлгээг тогтмол хугацаанд явуулж иржээ. (Дээрхи үнэлгээ, судалгааны сүүлийн 4 жилийн материалтай танилцав).

Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор НЭМ бакалаврын сургалтын төлөвлөгөөг шинэчлэх эрэлт хэрэгцээний судалгаа (судалгааны тайлан) хийж, үр дүнг хөтөлбөрт тусгаж ажилласан нь нилээн шинэлэг, орц гарцыг тодорхойлсон үр дүнтэй арга болжээ.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Хөтөлбөрийн төлөвлөлт, түүний шалгуурын дийлэнх нь SMART болон CREAM зарчимд нийцсэн, мэргэжилтний цогц чадамжид тусгасан ур чадварыг олгоход чиглэгдэн сургалтын орчин ялангуяа тухайлбал Орчин ба хөдөлмөрийн Эрүүл ахуйн магадлан итгэмжлэгдсэн лаборатори, олон улсын жишигт нийцэхүйц номын сан, оюутны үйлчилгээний төвүүдтэй болж сайжирсан байна.
2. Өмнөх магадлан итгэмжлэлийн хүрээнд зөвлөмж болгосоны дагуу тус хөтөлбөрт ашиглагдах сурах бичиг болон гарын авлагуудыг сүүлийн 5 жил мэргэжлийн чиглэл бүрээр боловсруулан ашиглаж байгаа төдийгүй англи хэл дээрх мэргэжлийн сурах бичгийн тоо эрс нэмэгдсэн байна. Номын сангийн суудлын тоо, түүний ажиллах орчин, цагийг нэмэгдүүлсэн бөгөөд цахим ном, хэрэглээний программ хангамж, түүний ашиглалт сүүлийн 5 жил төлөвлөлтийн дагуу амжилттай нэмэгдэж, хэрэглэгчийн тоо эрс өссөн.
3. Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалтанд оруулж, Хөтөлбөрийн зөвлөл, Багшийн хөгжлийн төвийг байгуулан ажилласнаар нийт багш нарын сургалтын хөтөлбөр боловсруулах, оюутны үйл ажиллагааг үнэлэх, эрдэм шинжилгээ, судалгаа хийх мэдлэг, ур чадвар нэмэгдэж байна. Гадаад хамтын ажиллагаа, хамтарсан төсөлт судалгааны ажлуудын тоо нэмэгдсэнээр багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны чадавхи нэмэгдэж байгаа төдийгүй төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийн агуулга өргөжиж байна. Багш хөгжүүлэх төвийг байгуулснаар багш нарыг хөгжүүлэх цогц бодлого сүүлийн жилүүдэд эрчимжин, гадаад болон дотоодын их дээд сургуулиудад урт, богино хугацааны 105 удаагийн сургалтанд 121 багш (2014 оноос хойш) хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн байна.
4. Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалт нь элсэгчидэд тодорхой, нээлттэй бөгөөд хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурын дагуу элсэгчдийг сонгон суралцуулж, шинээр элсэгчдийг дунд чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ажлыг хэвшүүлсэн байна.НЭМ судлалын хөтөлбөрөөр суралцагсдын сурлагын чанар жилээс жилд сайжирсан байна. Судлаач оюутан бэлтгэхийн тулд сургуулийн зүгээс мэргэжлийн тэнхим, багш нартай хамтарч үе шаттай сургалтуудыг зохион байгуулж ажилладаг байна.
5. Тэтгэлэгт сургалтанд хамрагдаж буй оюутнуудын тоо жилээс жилд нэмэгдэж, оюутны байгууллагын үйл ажиллагааг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр дэмжин ажиллаж ирсэн ба оюутны зүгээс гаргасан санал санаачлага, мэргэжлийн болон спортын уралдаан тэмцээн, урьдчилан сэргийлэх үзлэг, нийгмийн эрүүл мэндийн ухуулга нөлөөллийн ажил зэрэг олон талт ажлуудад байнга дэмжүүлэг үзүүлж, зарцуулах санхүүжилтийг сүүлийн 3 жилд өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлж ажилласан байна. АШУҮИС –ийн тэтгэлэгт хамруулах оюутаны тоо жилээс жилд нэмэгдэж сурлагын голчоос гадна, эмзэг бүлгийн оюутаныг хамруулж байгаа нь сайшаалтай байна. Оюутны шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ тэдний хувь

хүний эрх ашгийг эрхэмлэн, хүндэтгэх зарчмаар шийдвэрлэж ирсэн байна. АШУҮИС-ийн захирлын тушаалаар батлагдсан тогтсон дүрэм, журмын хүрээнд тодорхой судалгаа дүгнэлттэйгээр суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулж ажилладаг байна

6. НЭМ-ийн сургууль нь дотоод чанарын үнэлгээг тогтмол хийх нөхцөлийг бүрдүүлэн хөтөлбөрийн хороо байгуулан ажилласан байна. Хөтөлбөрийн хорооноос гарсан мэдээллүүдийг тэнхим нэгжүүдэд тогтмол хүргэж, эргэх холбоотой ажиллаж хэвшсэн байна. Суралцагсдаас гадна, төгсөгчид, ажил олгогчдоос санал асуулга авах, нээлттэй хэлэлцүүлэг хийх зэргээр сургалтын хөтөлбөрийн давуу ба сул талын талаар судалгаа хийн хөтөлбөрийн шинэчлэлийг хийдэг байна. АШУҮИС-ийн төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалт явуулах журмууд болон сургалтын технологи, чанарын хяналт хийх үлгэрчилсэн журам, оюутны мэдлэгийг үнэлэх журам зэрэг нэгдсэн бодлогоор хөтөлбөрийг чанартай явуулах нөхцөлийг бүрдүүлж тэдгээрийн хэрэгжилтийн явцад дотоодын чанарын үнэлгээг жил бүр хийж ажилласан байна
7. Нийт багш нарын 51% нь эрдмийн зэрэг цолтой бөгөөд 2014-2016 онуудад олон улсын болон дотоодын 9 төслийг хэрэгжүүлсэн, багш нарын хуримтлуулсан нийт IF оноо 196.45 болсон нь багш нарын эрдэм шинжилгээний ажлын чанар, тэдний чадавх олон улсын түвшинд хүрсэнийг харуулж байна. Жил бүр сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжил, нийгмийн үйл ажиллагааны чиглэлээр шалгуур үзүүлэлтийн дагуу багш нар өөрийн үнэлгээний тайлан бичиж, үнэлэх ажил тогтмол хийгдэж, 2014-2016 онуудад багш нарын аттестатчлалаар 95% нь ажлын гүйцэтгэл сайн хэмээн үнэлэгдсэн нь тус сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарыг хангалттай чадавхжсан баг бүрдсэн гэж үзэж байна.
8. Хичээлүүд хоорондоо агуулгын давхардалгүй, босоо, хэвтээ тэнхлэгт сайтар уялдсан байна. Цахим сургалтыг E-контентийн түвшинд боловсруулах, хөтлөн явуулах ажил шат дараатайгаар хийгдэж улам бүр дээшилсээр байна. Энэхүү үйл явцад бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн уялдаа холбоог оновчтой ашиглаж байгаа нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Хөтөлбөрийг байнга шинэчлэн сайжруулж байна
9. АШУҮИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын газраас төгсөлтийн өмнөх, төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа, дадлага, сонгон суралцах хичээл явуулах журмууд болон сургалтын технологи, чанарын хяналт хийх үлгэрчилсэн журам, оюутны мэдлэгийг үнэлэх журам зэрэг нэгдсэн бодлогоор хөтөлбөрийг чанартай явуулах нөхцөлийг бүрдүүлж байдаг. Шинэчлэн батлагдсан сургалтын төлөвлөгөөнд тусгасан нийт багц цагийн багтаамж өмнөх 2008 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөтэй харьцуулахад нэмэгдээгүй боловч, зарим хичээлүүд хасагдаж зарим шаардлагатай хичээлийг зах зээлийн эрэлт хэрэгцээ, сонирхогч талуудын санал хүсэлтийг тусган өөрчлөлт оруулсан байна. Мөн зах зээлд нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд анхаарч багш төвтэй хэлбэрээс оюутан төвтэй сургалт руу чиглэх, оюутан суралцах хугацаандаа эзэмших ур, чадвар,

мэдлэгийг мэргэжлийн хүрээнд эзэмших цогц чадамжуудтай уялдуулж өгсөн давуу талтай байна. Түүнчлэн НЭМ-ийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт батлагдсанаар төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, баталгаажуулахад чухал алхам болсон.

10. НЭМС- нь зөвхөн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан чиглэлээр баклаварын боловсрол олгож байгаа нь практик хэрэгцээ шаардлагыг хангахгүй эрүүл ахуйч тархвар судлагч нар шаардлагатай МХЕГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ болон бусад ЭМТ, нарийн мэргэжлийн эмнэлгүүдэдийг хэрэгцээг хангаж чадахгүй байна..

### **НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ**

1. Төгсөгчид өөрсдийн сурсан НЭМ хөтөлбөрийн хүрээнд эзэмшсэн онолын мэдлэг болон бусад ур чадварууддаа сэтгэл өндөр боловч эмнэл зүйн зарим ур чадварууд дутагдалтай байгаа (сувилахуйн болон эмчилгээний) тул төгсөлтийн дараах сургалтаар энэ чиглэлээр тусгах нь зүйтэй.
2. Төгсөгчдийн тоо цөөн байгаа учраас ӨЭМТ, СЭМТ-дэд НЭМ мэргэжилтэн одоо ч дутагдалтай байна. Сургалтын явцад эдгээр төвүүд дээр хийгдэх дадлагын үргэлжлэх хугацааг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн төгсөгчдөд ӨЭМТ-д нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнээр ажиллах хүсэл сонирхолыг өдөөх, боломж нөхцлийг таниулан, сурталчлах замаар мэргэжлээрээ ажиллах төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
3. Цаашид төгсөгчид болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хугацаанд авч, эргэх холбоог сайжруулахад санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.
4. Чанарын үнэлгээ, түүний баталгаажилтыг хангахын тулд сургуулийн төсөвт дотоод хяналт, шинжилгээний үнэлгээний зардлыг тусгах нь үйл ажиллагааг тогтмол, тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлэх.
5. НЭМС төсөв санхүүгийн хувьд харьцангуй бие даасан байдалтай байгаа боловч оюутанд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулах зардлыг нэмэгдүүлэхэд АШУҮИС-ийн зүгээс дэмжин ажиллах
6. Хөтөлбөрийн хэрэгжилт ялангуяа цогц чадамжид тусгасан ур чадварыг явцын болон төгсөлтийн шалтгалтаар үнэлэх үнэлгээг чанартай хийж гүйцэтгэх
7. Багшийг сонгон ажиллуулахдаа эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол, хэлний мэдлэгээс гадна харилцааны ур чадвар, ёс зүй, практик ажлын туршлага зэргийг харгалзах нь чухал
8. Цаашид хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их дээд сургуулиудад оюутан солилцооны тоогоо нэмэгдүүлэх.Гадаад оюутан элсүүлэх боломжийг бий болгох,

9. Оюутнуудаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх чадварыг нь сайжруулж, гадаад дотоодын эрдэм шинжилгээний хурлуудад оролцож өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх
10. Шилжилт хөдөлгөөнд хувийн болон хөтөлбөрийг хангахгүй байдлаас чөлөөлөгдөх, хасагдах шалтгааны эзлэх хувийг тодорхойлж, шаардлагатай бол шалтгаан болж буй үзүүлэлтийг багасгах, элсэлтийн шалгуурт тодорхой заалт бий болгон ажиллах шаардлагатай.
11. НЭМ мэргэжлийн онцлог, ялгаа, ач холбогдлын талаар ЭМБ-ын удирдлагуудад таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, дадлага хийх байгууллагын тоо, төрлийг нэмэгдүүлэх,
12. Эрүүл ахуйн тухай хууль хэрэгжиж эхэлсэн мөн эрүүл ахуйч, тархвар судлагч эмч нарын хэргэцээ шаардлага их байгаа учир цаашид эрүүл ахуйч тархвар судлаач эмч бэлтгэж төгсгөх асуудлыг нэн даруй шийдвэрлэх хэрэгтэй байна.

### **ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:**

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн “Нийгмийн эрүүл мэнд” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ...../М.Дармаа/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Гэрэлжаргал/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../С.Гантуяа/

**Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургууль “Нийгмийн эрүүл мэнд” сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь  
2017 оны 11 дүгээр сарын 16, 17**

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
<b>2017-11- 16</b>	<b>Пүрэв гараг</b>	
09:00-10:30	<b>Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна</b>	<b>Зохицуулагч</b>
	<b>Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ:</b> - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	<b>Шинжээчийн багийн ахлагч</b>
	<b>Сургуулийн захирал үг хэлнэ</b>	<b>Өөрийн үнэлгээний багийн ахлагч</b>
	<b>Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах:</b> - Удирлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	<b>Шинжээчийн багийн ахлагч</b>
10:30-12:00	<b>Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана</b>	<b>Шинжээчид</b>
12:00-13:00	<b>Сургуультай танилцах аялал</b>	<b>Шинжээчид</b>
13:00-14:00	<b>Өдрийн хоол</b>	
14:00-16:00	<b>Оюутнуудтай хийх уулзалт</b>	<b>Шинжээчид</b>
	<b>Багш нартай хийх уулзалт</b>	<b>Шинжээчид</b>
16:00-17:00	<b>Шинжээчид номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана</b>	<b>Шинжээчид</b>
17:00-18:00	<b>Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах</b>	<b>Шинжээчид</b>
<b>2017-11-17</b>	<b>Баасан гараг</b>	
09:00-10:00	<b>Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах</b>	<b>Шинжээчид</b>
10:15-11:15	<b>Төгсөгчидтэй хийх уулзалт</b>	
11:30-12:30	<b>Ажил олгогчидтой хийх уулзалт</b>	
12:30-13:30	<b>Өдрийн хоол</b>	
13:30-14:30	<b>Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах</b>	
14:30-17:00	<b>Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/</b>	
17:00-18:00	<b>Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.</b>	

## Оюутнуудын төлөөлөл

№	Нэр	Анги, дамжаа
1	О.Мөнхтулга	НЭМ 302
2	Х.Мөнхзул	НЭМ 303
3	Х.Хэрлэн	НЭМ 402
4	Б.Ирис	НЭМ 403
5	Л.Оюунтүлхүүр	НЭМ 501
6	Ц.Чогзол	НЭМ 504
7	М.Цацралтуяа	НЭМ 503
8	Ж.Миеэгомбо	НЭМ 501
9	Г. Хулан	НЭМ 501
10	А.Гантуяа	НЭМ 503
11	Ц. Дулмаа	НЭМ 503

## Төгсөгчдийн төлөөлөл

№	Нэр	Ажлын байр	Албан тушаал
1	Б.Золбоо	НМХГ	ЭМБСХХ-ийн ЭАХХХ-ын улсын ахлах байцаагч
2	Л.Идэрбат	НМХГ	ЭМБСХХ-ийн ЭАХХХ-ын улсын байцаагч
3	Г.Болдмаа	Сонгдо эмнэлэг	Тархвар судлаач
4	Мөнхзул	Сонгдо эмнэлэг	Статистикч их эмч

## Ажил олгогч нарын төлөөлөл

№	Нэр	Ажлын байр	Албан тушаал
1	С.Хонгорзул	МХЕГ	ЭАХХХ-ын улсын байцаагч
2	Д.Наранзул	ХӨСҮТ	Сүрьеэгийн тандалтын албаны тархвар судлаач
3	Т.Ундармаа	ХСҮТ	Статистик мэдээллийн албаны дарга
4	С.Ариунтуяа	НЭМГ	НЭМ-ийн албаны дарга
5	Б.Нарантуяа	ЭМХТ	Ерөнхий захирал
6	Д.Болдмаа	HSS компани	ХЭА-н захирал
7	Н.Оюунбилэг	Азийн хөгжлийн банк	ЭМСХХ-ийн төслийн менежер
8	Б.Баярмаа	СБД	НЭМ-ийн албаны орлогч